

Манмин Мэдээ

№ 58 2018 оны 3 сарын 25

Манминий залуучууд, халуун дотно ертөнцийг бүтээцгээе!

“Хойд Америкт олон хүмүүсийг Эзэн рүү удирдах эрх мэдэлт хүчит Эзэний боол болохыг хүсэн тэмүүлж байна.”



1



4

“Үнэгүй авсан Эзэний хайрыг дамжуулдаг цагдаа болмоор байна.”



2

“Бүх бие сэтгэлээр, дамжуулагдах Эзэний хайрыг хамтдаа мэдрэх нь хамгийн их аз жаргал.”



3

“Олон хүмүүст тусламж ба хүсэл тэмүүлэлийг өгдөг хайрын өмгөөлөгч.”

“Учир нь Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд та нарын дотор ажиллаж буй нь Бурхан юм” (Филиппой 2:13).

Тэмдэг болон гайхамшиг, эрх мэдэлт хүчний нөлөөг биеэр мэдэрч, ариун сайн мэдээгээр дасгалжуулагдаж буй Манминий залуучууд бусдаас нэг л өөр. Өөрийн байгаа газартаа Христийн анхилуун үнэрийг дэлгэрүүлж, Бурханы алдрын төлөө ариун болоод үзэсгэлэнт мөрөөдлөө биелүүлж буй 4 эрхэм залуусын гэрчлэлийг толилуулъя.

Ким Жэ юн АНУ, Калифорни Манмин сайн мэдээний төв

Ким Жэ юн сайн мэдээ тунхаглагч (зураг 1) нь 2015 онд АНУ-н баруун мужид орших нэр хүндтэй сургуулиудын нэг болох UCLA-г төгссөн бөгөөд мөн энэ сургуульдаа магистр зэрэг хамгаалсан юм. Ахлах сургуульд математикийн багшаар ажиллаж байхдаа, түүний аав Калифорни Манмин сайн мэдээний төвийн ахлагч Ким Хан рёл сайн мэдээ тунхаглагч Перу Манмин цуглаан руу илгээгдсэн тул энэ Сайн мэдээний төвийг ахлах Эзэний боол шаардлагатай болсон юм.

2017 оны 12-р сарын 17 ны өдөр тэрээр сайн мэдээ тунхаглагчаар илгээгдсэний Бурхан агуу төлөвлөгөөг ухаарч зүрх сэтгэлдээ маш талархаж байсан юм. Учир нь ахлах ангид байхдаа сайн мэдээний талаарх хүсэл мөрөөдөлтэй байсныг сануулж, цаг нь болохоор сайн мэдээ тунхаглагчаар илгээсэн байдаг.

“Ариун сайн мэдээгээр Хойд Америкийн олон хүмүүсийг Эзэн рүү удирдаж, эрх мэдэлт хүчийг дагуулсан Эзэний боол болоод эцэс төгсгөлийн үед хайрын хоньчинтой уулзаж, жинхэнэ итгэл юу болохыг ухааруулж өгсөн Бурхан Аавын ивээлийг хариулахыг өнөөдөр ч гэсэн залбирч байна.”

И Хан би Ерөнхийлөгч хувийн зохион байгуулалт хамгаалалтын алба

И Хан би өмгөөлөгч (зураг 3) нь шүүхийн сургалт судалгааны төвийн 44 дэх удаагийн тусгай бэлтгэлд хамрагдсанаар одоо Ерөнхийлөгчийн харьяа хувийн зохион байгуулалт хамгаалалтын албанд ажиллаж байгаа юм. Бага байхын хаана ч байсан маш дөлгөөн дүр төрхөөр бусдад үйлчил гэсэн И Жей руг тэргүүн пасторын сургаалийг сонсч өссөн юм.

Ажлынхаа байранд байхдаа сэтгэлд нийцэхгүй үйл явдалд өөрийнхөөрөө байхаас илүү сургаалийн үгийг бодож, суралцах сэтгэлээр хандах тул нэг л мэдэхэд түүнийг хүлээн зөвшөөрч, хүрээлж эхлэсэн байв. Тухайн үед шалихгүй жижиг зүйл гэж бодож байсан өөрийнх үйлдэл хураагдсаар нэг л мэдэхэд сайнаар хүндлэгдэн хүрээлэгдсэн олон хүмүүст цайлган атаархалыг төрүүлэх хэмжээний өхөөрдөм ажилтан болсон юм.

“Бусадтай адил архи ууж, хөгжилдөхгүй ч Бурхан ертөнцийн аргаар бус Өөрийн аргаар намайг удирдсаар ирсэн билээ. Илүү гүнзгий сүнс махан талын ийм чадвартай болоод Эзэний өгсөн сайны мэргэн ухаанаар олон хүмүүст хүмүүст найдварыг өгсөн өмгөөлөгч болохыг хүсч байна.”

Ким Сил ги Төв сүмийн урлагын зөвлөл, Power вошип бүжгийн баг

Ким Сил ги эгч дүү (зураг 2) нь бага байхаас л төвийн сүмийн урлагын зөвлөлийн Power вошип бүжгийн баг харж би ч бүжгээр Бурханд алдрыг өргөмөөр байна гэсэн мөрөөдөлтэй болсон юм. 2010 онд их сургуульд элсэн орж төдийгүй Сөүл ирсэнээр төв сүмийн оюутан багийн магтаалын баг, мөн урлагын зөвлөлд хамаарах Глори вошип багт үйлчилж байгаад 2015 онд, сая л өнгөрсөн хугацаанд мөрөөдөж байсан Power вошип багт орсон юм.

Мөн И Жей руг пасторын залбирлаар уушигны сүрьеэ өвчнөөс эдгэрч, эрх мэдэлт хүчийг биеэр мэдрэн, улам эрч хүчтэй Бурханыг хайрлан, үйлчилсээр алдрыг өргөж байгаа юм. Тэрээр хэл соёл, заншил өөр ч бүжгээр дамжуулан Эзэний хайрыг хүмүүстэй хамт мэдрэх нь маш аз жаргалтай байдаг гэсэн юм.

“Гадаадад сайн мэдээний ажлаар явах болгон бидний тоглолтыг үзээд сэтгэл хөдлөн нулимс унагаж, ариун сайн мэдээний ухаарал ба гайхамшигт эдгэрлийн хүч нөлөөг үзүүлэх Ариун Сүнсний хүчит үйлсийг хараад Бурханы гүнзгий болоод агуу хайрын мэдэрч байдаг. Илүү олон хүмүүс Эзэний хайрыг энэ мэт ухаарч, мэдрэн үзэсгэлэнтэй тэнгэрийн орон руу орохыг хүсч байна.”

Жон Ху сан Куа наг цагдаагийн хэлтэс эдийн засгийн мөрдөн байцаах тасаг

Жон Ху сан ахлах дэслэгч (зураг 4) нь Куа нагын цагдаагийн хэлтэс эдийн засгийн мөрдөн байцаах тасагт ажилладаг. Тэрээр интэрнетээр дамжуулан Манмин төв сүмийн тэргүүн пастор И Жей руг пасторын “Эхлэл номын тайлбар” сургаалийг сонсоод сүнс талын мэдрэмж ба агуу их ивээл авсанаар 2012 онд Манмины итгэгч болсон юм.

Мөрдөн байцаагчын хувьд төрөл бүрийн хүмүүстэй харьцдаг тэрээр Бурханы үгийн дагуу тэдэнд эвлэг хүндэтгэлтэй хандан Христийн анхилуун үнэрийг дэлгэрүүлэх тэрээр 2017 онд хэд хэдэн удаагийн талархалын бичиг болон шагнал авсан юм. Тэрээр одоо сүмд өөрийн харьяалах багт итгэмжтэйгээр үйлчлэх төдийгүй итгэгч нарын аюулгүй байдлын төлөөх үйлчлэлд өөрийгөө зориулж, ажлын талбар дээр Бурханы тусламжыг байнга мэдрч байдаг гэсэн юм.

“Манай баг гэмт хэрэгтнийг баривчлах үедээ байршил тодорхойгүй нөхцөлд ч маш амархан барих итгэлийн гайхамшигт мэдрэмжийг авч байсан. Манай хамт олон ийм зүйлтэй учирч байсангүй их гайхаж байсан. Үнэгүйгээр авсан Эзэний хайрыг дамжуулан дулаахан ертөнцийг бий болгосон цагдаа болмоор байна.”

Итгэл бол найддаг зүйлсийн бодит байдал

“Итгэл бол бидний найддаг зүйлсийн бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн” (Еврей 11:1-2).



И Жей руг пастор

Еврей номын 11-р бүлгийг харахад итгэл гэж юу болохыг, олон эш үзүүлэгчид Бурханаас яаж хариулт ба ерөөл авсан болохыг мэдэх боломжтой юм. Ийм итгэлийн тухай Бурхан “Зүрх сэтгэлдээ өвөрлөж, найддаг зүйлс нь бодит байдлаар бий болж, харагдахгүй зүйлс нь баталгаа болон гарч ирэх” талаар айлдсан байдаг.

Тэгвэл итгэл юу болох, бид яаж итгэлээрээ хариулгаа авах вэ?

1. Боломжгүй зүйл байхгүй сүнслэг итгэлийн ертөнц

Өнөө үед шинжлэх ухаан болон анагаах ухаан өндөр хурдацтай хөгжиж байгаа ч хүний хүч чадлаар боломжгүй үйл явдлууд ихээр гарах болсон. Өдөр өнгөрөх тусам шинэ төрлийн өвчний төрөл олширч, гэнэтийн осол аваарь, гай гамшиг тасрахгүй болсон ба эдгэршгүй болон хүнд өвчнөөр амиа алдаж буй хүмүүс олширсоор л. Эрх мэдэл, нэр алдартай байсан ч хормын л дотор бүх зүйлээ алдах үе ч байна. Энэ мэт хүний хүч чадлын гадна байх эдгээрийг шийдэж чадахгүй тул хязгаарлагдмал байдал дотроо дэмий л санаа алдан байх нь бидний амьдарч буй махан биеийн ертөнцийн шинж чанар гэлтэй.

Үүний эсрэгээр итгэлийн ертөнц нь найдаж буй зүйл нь бодит байдлаар гарч, харагдахгүй зүйлүүдийн баталгаа болон гарч ирэх нь сүнслийн ертөнцийн шинж чанар юм. Бодит байдлаас хамааралгүй, ямар нэгэн хязгаар юм уу боломжгүй зүйл гэж байхгүй эцэс төгсгөлгүй ертөнцөд

бүхнийг бүтээгч Бурханы хүчээр эдгээр нь бий болдог. Библийн 66 н номд ямар хүмүүс нь энэ сүнслэг итгэлийн ертөнцийг хүч нөлөөг мэдэрч, Бурхан тэдний ямар дүр гардаг. Хаадын дэд номын 5-р бүлэгт Нааман жанжин бол Бурханы хариулт ба ерөөл авсан тухай жишээнүүдийн нэг нь юм.

2. Нааман жанжины хариулт авсан учир

Нааман нь Арам улсын их цэргийн жанжин бөгөөд байр сууриар хааны дараа орох хүн ч гэсэн харамсалтай нь тухайн үед хүний аргаар огт эдгэрэх боломжгүй өвчин туссан юм. Гэхдээ тэрээр Бурханы хүч чадлаар хоромхон зуурт л эдгэрсэн юм. Бурханд итгэдэг Израйль ард түмэн ч хариулт авч чадаагүй байхад, Бурханд итгэдэг ч үгүй Нааман хариулт (Лук 4:27) авсан учир нь юу байв?

Нэгдүгээрт, Зүрх сэтгэл цайлган сайн тул.

Ихэнх хүмүүс өндөр байр сууринд очвол зүрх сэтгэл нь хүртэл өндөр, бардам болсоноор бусад хүний үгийг сонсьё гэдэггүй байдаг. Гэтэл Нааман бол өөрийн шивэгчдийн үгийг ч алдалгүй сонсдог цайлган сэтгэл хүн байсан юм.

Тэрээр дайн тулааны үед Израйль газраас боолоор баригдан ирсэн шивэгчнүүдийн дунд нэгэн нь “Самарид байгаа эш үзүүлэгч дээр очвол уяман өвчнөөсөө эдгэрч чадна” гэсэн үгийг сонсоод Бурханы хүн Елишатай уулзахаар шууд Израйль руу явсан байдаг.

Хоёрдугаарт, Тэрээр Бурханы өмнө итгэлээрээ чин сэтгэлээр бэлдсэн учир.

Нааман нь өвчнөө эдгээлгэхийн тулд арван мөнгөн талант болон зургаан мянган алт, арван ээлжийн хувцас аван Израйль руу явсан юм (Хаадын дэд 5:5). Суулгалгүйгээр хурааж авах юм уу, өөрийн хийснээс илүү ихийг хүсдэг сэтгэлээр бус зөвхөн хариулт авъя гэсэн чин сэтгэлээр өөрийн байр сууринд нийцтэй байдлаар бүхнээ зориулсан өргөл бэлтгэсэн байдаг (Матай 6:21). Бурхан энэ өргөлд агуулагдсан сэтгэлийг итгэлээр хүлээн авч, өргөснийх нь дагуу хариулж өгөхөөр ивээсэн юм.

Гуравдугаарт, Эш үзүүлэгчийн дамжуулсан Бурханы үгэнд дуулгавартай дагасан тул.

Нааман жанжин өвчтэй биеэр хол газраас хайж ирсэн ч Елиша эш үзүүлэгчийн царайг харж чадалгүй, түүний зарцын Иордан голын усан долоон удаа булхвал уяман өвчнөөсөө эдгэрнэ гэсэн үгийг л сонссон юм. Махан биеийн хүн тул Елиша эш үзүүлэгчийн итгэж чадалгүй, харин өөрийг нь үл тоосон мэтээр буцаж харих гэж байлаа (Хаадын дэд 5:10-12).

Гэтэл түүний боолууд нь “Эцэг минь” гэж дуудан түүнийг ятгаж нутаг буцахыг нь хориглож байсан (Хаадын дэд 5:13). Энэ нь түүний хувьд өөрийн зарц нартайгаа ч төрсөн хүүтэйгээ адил харьцдаг байсныг илтгэж байгаа юм. Нааман хоромхон зуур сэтгэл нь тавгүйтэж, гомдсон ч боолуудынхаа үгийг сэтгэлдээ эргэцүүлэн тэдний үгээр шийдэхээр болсон юм.

Дөрөвдүгээрт, Эцсээ хүртэл хувирах сэтгэл байгаагүй юм.

Елиша эш үзүүлэгч Наамантай уулзалгүй “Иордан голд очиж долоон удаа булх” гэж дамжуулсаны учир юу вэ? Сүнс талаар долоо гэдэг тоо нь төгс чанарыг агуулдаг тул, ус нь Бурханы үгийг илэрхийлж, Иордан голын усанд долоо удаа булх, угаа гэсэн нь Бурханы үгэнд төгс дуулгавартай бай гэсэн утгатай юм.

Нааман Елишагийн үгийн дагуу төгс дуулгавартай байснаар эцэст нь Бурханы агуу хүч нөлөөг мэдэрсэн юм. Долоо дахь хүртэл биеэ усанд булхаад хартал уяман өвчин нь эдгэрч, биеийнх нь арьс яг л няох хүүхдийн арьс шиг цэвэрхэн булбарай болсон байлаа (Хаадын дэд 5:14).

Тавдугаарт, Авсан ивээлээ хариулж мэддэг.

Нааман ингэж эдгэрснийхээ дараа өөрийн биеэр хамт яваа хүмүүстэйгээ хамт дахин Елиша эш үзүүлэгч дээр очоод талархалаа илэрхийлэх төдийгүй Израйлийн Бурхан л жинхэнэ Бурхан болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг (Хаадын дэд 5:15-17).

Түүнд энэ мэт Бурханы хуулийг заах хүн байхгүй Эзэн Бурханы

тухай сонсож байгаагүй ч сая уяман өвчнөөс эдгэрснээрээ Израйлийн Бурхан л жинхэнэ Бурхан болохыг баттай ойлгож авсан юм. Гэхдээ өөрөө хааны албат учраас нутагтаа буцаж очоод хаантай хамт хиймэл шүтээний өмнө очих ёстой болдог тул энэ тухайгаа Бурханаас урьдчилан уучлалт гуйж байгааг харж болно (Хаадын дэд 5:18).

Энэ мэт Бурханы өгсөн ивээлд талархаж мэддэг ба нэг удаа уулзсан Бурханаас урвах сэтгэлгүй сайхан сэтгэлтэй тул Бурхан түүгээр дамжуулан алдрыг авсан юм.

3. Итгэл бол Бурханы хүчийг буулгаж ирэх арга зам

Ихэнх хүмүүс итгэлтэй гэсэн мөртлөө яг хэцүү байдалд ороод ирэхээрээ “Би болохгүй байна. Чадахгүй нь. Тэр бол мундаг, сайн итгэлтэй хүмүүст л хамааралтай” гэх зэрэг өөдрөг бус үг хэлдэг ч үнэхээр Бурханд итгэдэг бол хариулт нь хэнд ч адилхан ирдэг. Итгэл бол намайг болон бүтээгч Бурхантай холбосон утас, уяа мэт зүйл учраас бүтээгч Бурханы хүчийг буулгах гарц болж өгдөг.

Тиймээс юу ч байсан итгэлээрээ залбирч, гуйснаараа хариултыг авч, (Марк 11:24) ямар ч зүйл саад болж чадахгүй юм. Бурханд итгэх итгэлээр боломжгүй зүйл байхгүй сүнслийн ертөнцийн үйлс тэр чигтээ илрэн гардаг болохоор юм.

Хэрвээ итгэлээрээ гуйлаа ч гэсэн хариулт авч чадахгүй бол энэ нь шуналын хүслээр буруу хандлагаар гуйсан учраас юм (Иаков 4:3). Өөрийн хүслийн дагуу гуйна гэдэг нь хэдийн Бурханы өмнө итгэл биш бөгөөд хараахан хариулт авах хэмжээний бэлэн болоогүй байна гэсэн үг ба хичнээн итгэлээ үзүүлж байна гээд Бурхан хариулахгүй боломжгүй юм.

Хайрт итгэгч та бүхэн, Итгэл бол зөвхөн амаараа “итгэж байна” гэж биш баталгаа дагалдах ёстой байдаг. Итгэлийн баталгаа нь огтхон ч дуулгавартай дагахын аргагүй зүйлд ч дагах явдал бөгөөд библийн 66 номын бүх үгэнд тэрчлэн итгэх явдал юм. Бурханд итгэсэнээр бүх зүйлд итгэлийн баталгааг үзүүлж, агуу алдрыг өргөхийг Эзэний нэрээр хүсэн ерөөе.


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637
чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org

Амьд орших Бурханы НОТОЛГООНУУД



Есүс “Хэрэв чи итгэвэл
Бурханы алдрыг харна”
(Иохан 11:40)

гэсний дагуу Бурханд найдах
итгэл нь үнэхээр төсөөлөхийн
аргагүй гайхамшигт
зүйлүүдийг мэдэрдэг.

Төрөл бүрийн өвчнөөс эдгэрч,
гайхалтай хариулт болон
ерөөл авч, төрөл бүрийн
осол аваариас ч хамгаалагдах
зэрэг боломжгүй юм байхгүй
Бурханы агуу хүчийг мэдэрч
гадаад итгэгч нарын
гэрчлэлээр дамжуулан амьд
орших Бурхандаа
алдрыг өргөж байна.



Амийн үг сургаал, миний сүнс сэтгэлийг минь өөрчилж, аз жаргалтай болгож өгсөн

Эхлэл номоос эхлэн Илчлэлт ном хүртэл, манай сүмд тэргүүн пастор И Жей руг пасторын үй олон залбирал ба мацаг барилтаар Ариун Сүнсний бялхал дотор тайлагдсан амийн үг сургаалиар арвин дүүрэн байдаг. Сүмийн сайт (www.manmin.org)-д сүнс талын үг сургаалийг үнэгүйгээр хүлээн авч, гадаадын олон хүмүүс И Жей руг пасторын сургаалыг сонсоод сүнс сэтгэлийн эдгэрлийг авч, өөрчлөлт болон амийн замаар хөтлөгдөж байгаа билээ.

Виктор Чевчиглашев итгэгч (46 нас, ОХУ) нь CNL болон TBN Россия суваг (Оросын Христийн суваг)-р дамжуулан И Жей руг пасторын сургаалыг сонсоод сүнсний гүн утгатай сургаалийн амтанд орсон байв. Тэрээр хэлэхдээ “Өөр бусад сургаал айлдагч нараас илүү даруу дөлгөөн, шударга байсан ба библийн тайлахад хэцүү, удаан бодож



явсан зүйл маш тодорхой болоод оновчтой хариулж өгсөн” гэж байлаа. Ажил хийх үед гарынх нь хуруу байнга хавддаг, хумс орчмоор идээлдэг байсан мөн хөлний арьсны үрэвсэлтэй тэрээр цаг орон үл хамааран И Жей руг пасторын залбирлаар төгс эдгэрсэн юм.

Түүний гэр бүл ч гэсэн сүмд бүртгэгдэн, интэрнетээр Манмин төв сүмийн мөргөлтэй хамт оролцож, ариун сайн

мэдээг хөршүүддээ тарааж байгаа юм.

Паг Жун ёон итгэгч (43 нас, Солонгос төв сүм 3-р их бүлэг 32 хэсэг) нь өмнө нь өөр сүмд итгэлийн амьдралаар амьдарч байхдаа аз жаргалыг мэдэрч чадахгүй байлаа. Тэрээр “Энэ ертөнц дэндүү атгаг болж, гэм нүгэл рүү уруу татах хүч дэндүү их тул би энэ тэмцэлд ялж чадах болов уу? Ичгүүрт аврал ч болтугай авах сан” гэж бодох хэмжээний байсан юм.



Тэрээр Юу түбээр дамжуулан И Жей руг пасторын “Эрх мэдэлт хүч” гэсэн видеог үзээд “Ийм хүчийг үйлддэг пастор ямар сургаал заадаг бол?” гэж ихэд сонирхсон байна.

Олон сургаалиудын дундаас эхлээд “Загалмай үг” гэх сургаалийг сонссоны дараа үргэлжлүүлэн сонссоор байв. Тэрээр хайрыг өгч авалцах жинхэнэ үр хүүхдийг олохын төлөө энэ газар дээр хүн төрөлхтөнийг дасгалжуулж буй Бурханы хайрыг ухаарч, сэтгэлл их хөдөлсөн байв. Тэгээд гэр бүлийнхэнтэйгээ хамт Манмины итгэгч болж, одоо итгэлийн жинхэнэ аз жаргалыг амтыг мэдэрч, гэм нүглээс хамааралгүй итгэгч болж, гэр бүл ч Эзэн дотор эв нэгдсэн ерөөлийг авсан юм.

“Нэг удаагын залбирлаар архаг ходоодны шарх болон улаан хоолойн үрэвсэлээс эдгэрсэн”

Жон Сун и сүмд үйлчлэгч
(40 нас, 2 Канаан бүлэг)



2 жилийн өмнөөс хааяа маш хүчтэй цээж хорсдог байлаа. Цаг хугацаа өнгөрөх тусам тэр шинж тэмдэг дээшилсээр хоолой яг түлэгдэж байгаа мэт эвгүй мэдрэмжтэй байлаа. Дотор муухайран огиудас хүрч, унтах гээд хэвтэхээр ходоод өвдөн, цээж шатах мэт болоод хэвтээд унтах боломжгүй босоо байж байлаа.

2016 оны 9-р сард ходоодны дуран болон холбогдох

шинжилгээ хийлгэснээр ходоодны шарх болон улаан хоолойн үрэвсэлтэй болохоо мэдсэн юм. Улаан хоолойн үрэвсэл маань хүндэрч, олон хэсэгт цус шүүрч байсан юм. Эм уусан ч дээрдсэн юм байхгүй, 1 жилийн дараа 2017 оны 8-р сард ерөнхий шинжилгээ хийлгэтэл урьдын л адаил ходоод болон улаан хоолойн шарх нь хэвээрээ байлаа.

2017 оны 12-р сарын 30 өдөр үүрээр Баасан гаригийн оройн цуглаан дуусаад И Жей руг тэргүүн пасторын залбирал авсан юм. Гэтэл унтаад босоход гайхалтай нь цээж хорсолт болон өмнөх бүх шинж тэмдэгүүд бүгд арилсан байлаа. Ямар ч эвгүй мэдрэмж байхгүй бол хоол ч сайн шингэж байлаа. Тэргүүн пасторын залбирлаар ходоодны болон улаан хоолойн шархнаас бүрэн эдгэрсэн юм. Халлелүяа!



▲ Ходоод, улаан хоолой дах цус шүүрч байгаа харагдаж байгаа байдал.

“Баруун гар хугарсан ч хагалгаанд оролгүй бүрэн бэхжсэн”

Жон Жү ёон ах дүү
(14 нас, 1-р Их бүлэг 9-р хэсэг)



2017 оны 11-р 4 нд тоглоомын талбай дээр халтирч унаад баруун гараа гэмтээсэн билээ. Эмч хэлэхдээ гар чинь бүр хугарсан байна хагалгаанд орох хэрэгтэй гэсэн юм. Хэрэв тэгэхгүй бол өсөлт

нь зогсож, гар шуу богиносх магадлалтай, ясыг нь зөв байрлуулахгүй бол өсөх явцад гар чинь эргэх юмуу элдэв гажигтай болно гэсэн юм. Гэвч би Бурханаар эдгээлгэхийг хүсч зүгээр гэртээ очоод И Жей руг тэргүүн пасторын автомат хариулагч дах залбирал авсаны дараа өвчин хөндүүр аажим багасаж тэр шөнө маш сайн унтсан юм.

Эмч хэлэхдээ гарын яс бүрэн хугарсан болохоор өвдөлт ихтэй байна гэсэн ч ерөөсөө өвдөөгүй. Мөн даниел залбирлын цагт очоод маш их уйлан гэмшсэн юм.

11-р сарын 17 нд ууланд залбирч буй тэргүүн пастортаа захидал бичиж залбирлын хүсэлт явуулж 12-р 2 ны өдөр эмнэлэгт рентген зураг авахуулахад эмч зургийг хараад яс нь маш сайн бэхжсэн байна гэсэн юм. Халлелүяа!

Залбирал авахын өмнө



► Мөр ба гарын шууны ясны голд байх атгаал чөмгийн үзүүр хэсэг хугарч мултарсан байдал.

Залбирал авсаны дараа



► Хугарсан хэсэгт зөөлөн эдээр хучигдаж сайн бороолсон байдал.

“Тархины цусан хангамжын саатлын улмаас үүдсэн саажилтаас бүрэн эдгэрсэн”

Мэн Чан гыг сүмд үйлчлэгч
(67 нас, Төв сүм
Хятадын 1-р бүлэг)



2017 оны 12-р сарын 26 ны мягмар гариг, Үүрээр ажилдаа явахаар гадаа гартал бие маань зүүн

тийшээ далих мэдрэмжтэй болсон. Дахин гэртээ орох гэтэл хөл болон хэл ч гэсэн саажиж шатаар өгсөх, юм ярихад төвөгтэй болов.


Арай хийж гэртээ орж ирээд охины дуудсан түргэн тэргээр эмнэлэгт очтол шинжилгээний хариу тархины цусан хангамжын саатал гэсэн юм. Эмч хэлэхдээ тархины гурван хэсэгт эд эс гэмтэж, бүрэн эмчлэгдэх боломжгүй гэсэн юм.

Гэвч 12-р сарын 29 нд үдээс хойш 5 цагын үед И Жей руг тэргүүн пасторын залбирлыг авсан ы дараа хөлд хүч орон таяггүйгээр ганцаараа алхдаг болж, бие нэг тийш хазайхгүй болсон байв.

Баасан гаригийн оройн цуглаан дуусаад 30 ны өдөр үүрээр 4 цагын үед И Жей руг тэргүүн пастортай гар

барих үед саажилттай байсан хэл тавирч, хэвийн ярьдаг болсон юм. Халлелүяа!

Залбирал авахын өмнө



► Уураг тархины доод хэсгээр болон зүүн тархины доод хэсэгт цус хурсан байдал.

“Манай гэр бүл ерөөлөөр бялхаж байна”

Пэг Юн чол сүмд үйлчлэгч (53 нас, 1-р Их бүлэг 6-р хэсэг)



Саяхан Эзэн дотор итгэлээр юу ч хийж чадах, үр жимс гаргаж чадах ивээл үнэхээр аз жаргалтай байна. Би Сөүлийн орон сууц хот байгуулалтын газар ажилладаг ба олон жилийн турш И Жей руг тэргүүн пасторын залбирлаар өөрийн хариуцдаг хэд хэдэн барилгын талбай дээр ямар нэг осол аваар гаралгүй

хамгаалагдсаар ирсэн билээ.

Мөн ажил дээрээ ч И Жей руг тэргүүн пасторын сургаалын дагуу өгөгдсөн үүрэг албаа итгэмжтэй гүйцэтгэн, эргэн тойрондоо үйлчлэх сэтгэлээр хичээх үед 2017 оны 12-р сарын 31 нд Сөүл хотын даргын жуух бичгээр шагнуулсан юм. Үер усны аюулаас хамгаалах үйл ажиллагаанд оролцож, иргэдийн талархалыг хүлээж Бурхандаа алдрыг өргөсөн юм.

Хүү Пэг Жун хёон (21 нас) таван настай байхдаа ярианы бэрхшээлтэй их ээрдэг байсан ч итгэлээрээ тэргүүн пастортой гар барьсаны дараа засарсан юм. Энэ мэт Бурханы хүчийг мэдэрсэн хүү маань одоо гадаад хэлний чиглэлээр мэргэшиж, Бурханы хаанчлалд хэрэглэгдэхээр залбирч, 2018 онд Солонгосын гадаад хэлний их сургуулийн Араб хэлний ангид 4 жилийн төлбөрийн 50 хувийн тэтгэлэгт багтсан ерөөлийг авсан юм. Охин Пэг Жи хёон (19 нас) маань бага байхдаа ухарч байгаа машинд мөргүүлж үхэх дөхсөн ч хоньчины орон зайд хамгаалагдсан юм. Энэ жил Сурагчын багт ахлах ангийн ерөнхий удирдагчаар сонгогдож, сургуульд сурлагын амжилтаар тэргүүн байрын шагнал авсан нь талархалтай юм.

Эхнэр Ким Ми уг халамжлагч (49 нас) өөрийн бүлэгтээ хэсгийн ахлагчийн үүрэг аваад итгэгч нараа эргэн, залбиралд зориулах тул талархал баяр хөөрөөр дүүрэн байна. Бүх гэр бүлээрээ үзэсгэлэнтэй тэнгэрийн орны тэмүүлэл дотор жинхэнэ ерөөлийн замаар удирдаж өгсөн Бурхан Аавдаа бүх талархалыг өргөө.

“4-р зэргийн цусны хорт хавдраас эдгэрсэн”

Тара Син итгэгч (28 нас, Энэтхэг, Дели Манмин цуглаан)



2017 оны 4-р сараас биед маш хүнд шинж тэмдэг илэрсэн. Бүх биеэр болон толгой маш хүчтэй өвдөж, арьс загатнаж, унтаж чадахгүй болохоор бие маань өдөр ирэх тутам суларч өдөржингөө орондоо хэвтэж өнждөг болсон юм. Үүний дараа байдал улам хүндэрч юу ч идэж чадахаа байлаа.

Эмнэлэгт шинжилгээ хийлгэтэл цусны хорт хавдрын 4-р зэрэг гэсэн ба хорт хавдрын эс бүх биеэр тархсан байдалтай ба химийн эмчилгээ хийсэн бүрэн эдгэрэх найдваргүй, хэзээ үхэж болзошгүй гэсэн юм.

Яг л үхэхээс өөр аргагүй болсон надад нэг зүйл санагдлаа. Хоёр сарын өмнө сайн мэдээ сонсож, очсон Дели Манмин цуглаанд сонссон гэрчлэл. Солонгос Манмин төв сүмийн тэргүүн пастор И Жей руг пасторын залбирлаар төрөл бүрийн өвчнөөс эдгэрсэн хүмүүсийн гэрчлэл байсан юм.

Би GCN (Жи Си Эн) телевизээр оройн Даниел залбирал оролцож, өнөөг хүртлэх амьдарлаа эргэн харж гэмшин чин сэтгэлээсээ залбирал хийж эхэлсэн юм. Мөн өдөр бүр гурван удаа И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлыг MP3-р авч мөн И Жей руг пасторын “Загалмайн үг” сургаалийг ч сонссон юм. Үүний хамт тэргүүн пастораас залбирал хийж өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12) аар Ким Сан хи пастор маш олон залбирал хийж өгсөн юм. Түүний үр дүнд бие маань бага зэрэг хөнгөрч хүч тэнхээтэй болж байлаа.

Мөн 8-р сард болдог “2017 оны Манмин Зуны цуглаан”-ы тухай сонсоод төгс эдгэхийн тулд мацаг барин залбирлаар бэлтгэсэн юм. Тэгээд 8-р сарын 7н зуны цуглаан эхний өдөр GCN (Жи Си Эн) телевизээр зуны цуглаанд оролцож, тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлыг автал гайхамшигтай зүйл болсон юм. Залбирал хийж дуусахад Ариун Сүнсний галыг авч бүх биеэр тархаж, маш их хөлөрч, түүний дараа өмнөх шинж тэмдэг бүрэн арилсан байлаа. Халлелуяа.

Арваад өдрийн дараа эмнэлэгт шинжилгээ өгөхөд “хорт хавдрын эс алга болсон байна” гэж маш их гайхаж байлаа. Эдгээж өгсөн Бурхан Аавдаа бүх л талархал ба алдрыг өргөө.

Гэнэтийн гал түймэр, аймшигт ослоос бүрэн хамгаалагдсан юм.



Филиппин Тересита Тамаё итгэгч (67 нас, Манилла Манмин цуглаан) нь том хэмжээний гал түймэр болон золгүй явдлаас бүрэн хамгаалагдсан юм. 2018 оны 1-р сарын 4 ний өдөр үдээс өмнө 10цагын үед хүүхдүүд галаар тоглосны улмаас эхлэсэн гал түймэр 20 гаруй галын командын

машин оролцоотойгоор үдээс хойш 5цагын үед л сая унтрааж чадсан юм. Тересита итгэгч хөршүүд болох 50 гаруй айлын гэр орон бүрэн шатаж, хойд талынх нь айлын гэр шатахад гайхалтай нь түүний гэр гал ойртохгүй байлаа.

“Тэргүүн пасторын залбирлаар Ома хар салхинаас хамгаалагдсан итгэгч нарын санаанд орж, хариуцагч пастораар дамжуулан залбирлын хүсэлт явуулсан юм. Маш гайхалтай нь манай гэр л бүрэн хамгаалагдаж хоньчины орон зайг мэдрэх боломж олдсон юм” гэж гэрчилсэн юм.



Кения Аргунс Одака Сандэ ах дүү (23 нас, Найроби Манмин цуглаан) нь 2017 оны 12-р сарын 27нд барилга дээр 4-р давхарт ажил хийж байгаад боолтыг нь дутуу холбосон шатан дээр гишгэн холбирч доош унан осолд орсон юм. Ажилчид нь яаралтай эмнэлэгт

хүргэж, биеийн байдлыг шалгаж үзтэл нүүрэн дээрээ халыг шалбарснаас өөр ямар ч бэртэл гэмтэл байхгүй байлаа.

“Тухайн үед толгойгоороо газар руу унаж байсан ба гэнэт агаарт нэгэн хүч миний эргүүлж байгааг мэдээд тэр агшинд толгойгоороо биш баруун гараараа эхлээд газарт хүрч унасан” гэж хэлсэн юм. Түүний баруун гарыг рентген зураг авахад ямар ч бэртэл гэмтэл илрээгүй юм.




Молдав Василий итгэгч (31 нас, Молдав Манмин цуглаан) нь 2016 оны 10-р сарын 11ний өдөр жолоо барьж байхдаа алдаа гаргасны улмаас хажуу талын машинтай шүргэлцэж, эсрэг урсгалаас ирж буй машин түүний машиныг маш хүчтэй мөргөж машины урд хэсгийг нь жолоочын

суудал хүртэл чихэгдсэн аймшигт осол болсон юм.

“Гайхалтай нь хажуу талын машин яг миний биед хүрэхийн өмнө зогсож арайхийн машинаас гартал өөрийн биеийг шалгаж үзтэл бэртсэн зүйл огт байхгүй эв эрүүл байсан юм. Хоньчины орон зайд хамгаалагдсан юм.” гэж гэрчилж байлаа.

Мөн И Жей руг пасторын сургаалийг сонссоноор Манмины итгэгч болсноор л тэрээр өөрийгөө эргэн харах боломжтой болж, амийн үг сургаалиар амьдрал минь өөрчлөгдсөн гэсэн билээ.



УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manmininen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин